



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Гурвансайхан сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2022/2/НА-СТА-ТЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Мандалговь хот 2022 он</p>	<p>Дарга,тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: <a href="mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn">Munkhtogtokhr@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Х.Наранцацрал Утас: 70592225 Цахим хаяг: <a href="mailto:Narantsatsralkh@audit.gov.mn">Narantsatsralkh@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: Т.Батсайхан Утас: 70593113 Цахим хаяг: <a href="mailto:batsaikhant@audit.gov.mn">batsaikhant@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: Т.Оюун-Эрдэнэ Утас: 70593113 Цахим хаяг: <a href="mailto:Oyunerdenet@audit.gov.mn">Oyunerdenet@audit.gov.mn</a></p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Товчилсон үгийн жагсаалт.....	2
2. Аудитын санал дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Материаллаг байдал.....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	14
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.1 Залруулсан алдаа.....	15
4.2 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	17

## 1.Товчилсон үгийн жагсаалт

---

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХШҮДАХ	Хяналт, шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЭМТ	Эрүүл мэндийн төв

---



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2022.03.25. № 93

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГУРВАНСАЙХАН СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Э.АДЪЯАБААТАР ТАНАА**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Дундговь аймгийн Гурвансайхан сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Гурвансайхан сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар Сум хөгжүүлэх сангаас төсөл шалгарч, зээл авсан нэр бүхий 2 төсөл хэрэгжүүлэгч гэрээнд заасны дагуу үндсэн зээл, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн, зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй, аж ахуйн нэгж байгууллагаас өгсөн хандивыг Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд төвлөрүүлэлгүй, зориулалт бусаар зарцуулсан, санхүүгийн нэгтгэсэн тайлангийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийг сумын ИТХ-ын шийдвэргүйгээр бууруулан тайлагнасан зэрэг зөрчил илэрсэн нь материаллаг дүнтэй бөгөөд санхүүгийн тайланд бүрэн тархаагүй.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан болон нэгтгэгдсэн байгууллагуудын залруулагдаагүй алдаа, зөрчлүүд нь урьдчилан тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 1.9 дахин их, ангилал, үнэлгээ ба хуваарилалт, толилуулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**


0012020921

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА



Р.МӨНХТОГТОХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		943,082.2	943,729.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	435,933.3	421,829.9
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	197,217.8	247,583.8
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	309,931.1	274,316.3
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		7,671,305.7	9,895,264.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	7,671,305.7	9,895,264.2
39200	Биет хөрөнгө		7,514,822.2	9,725,323.8
39300	Биет бус хөрөнгө	13	156,483.5	169,940.4
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		8,614,387.9	10,838,994.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		1,910,247.6	1,910,426.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	22,741.8	22,921.0
41300	Өглөг	17а, 17б	22,741.8	22,921.0
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		1,887,505.8	1,887,505.8
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	1,887,505.8	1,887,505.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		6,704,140.2	8,928,567.4
51	Засгийн газрын хувь оролцоо		6,704,140.2	8,928,567.4
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		2,003,135.0	2,003,135.0
51200	Хуримтлагдсан үр дүн		3,200,707.4	5,425,176.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,500,297.9	1,500,255.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		8,614,387.9	10,838,994.2

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		3,509,875.9	5,363,341.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО		125,648.4	191,747.9
110	Орлогын албан татвар		59,492.1	32,890.9
1100	Хувь хүний орлогын албан татвар		59,492.1	32,890.9
113	Хөрөнгийн албан татвар		840.0	74,312.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж		65,316.3	84,544.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	592,317.9	2,953,573.2
120	Нийтлэг татварын бус орлого		590,117.9	2,953,573.2
121	Хөрөнгийн орлого		2,200.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,791,909.6	2,218,020.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	3,194,499.7	3,124,927.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,194,499.7	3,124,927.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,340,624.2	3,054,068.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,245,909.1	1,269,025.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		154,316.9	165,005.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		201,629.3	213,117.2
2104	Хангамж, бараа материалын зардал		51,769.6	134,171.9
2105	Нормативт зардал		70,591.4	259,897.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		13,058.6	21,882.7
2107	Томилолт, зочны зардал		9,132.4	7,129.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		35,656.2	22,833.0

Дундговь аймгийн Гурвансайхан сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал		558,560.8	961,006.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		853,875.4	70,859.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		315,376.2	2,238,414.0
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		0.0	235.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		53,690.7	14,129.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		261,685.5	2,224,520.5

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код :	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,446,339.9	0.0	6,446,339.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	19,206.7	0.0	19,206.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,465,546.6	0.0	6,465,546.6
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-23,091.9	0.0	-23,091.9
9	Тайлант үеийн үр дүн	261,685.5	0.0	261,685.5
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,704,140.2	0.0	6,704,140.2
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,704,140.2	0.0	6,704,140.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-51.2	0.0	-51.2
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,704,089.0	0.0	6,704,089.0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-42.0	0.0	-42.0
19	Тайлант үеийн үр дүн	2,224,520.5	0.0	2,224,520.5
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	8,928,567.4	0.0	8,928,567.4

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		3,017,712.6	2,489,250.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО		125,648.4	191,747.9
110	Орлогын албан татвар		59,492.1	32,890.9
1100	Хувь хүний орлогын албан татвар		59,492.1	32,890.9
113	Хөрөнгийн албан татвар		840.0	74,312.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж		65,316.3	84,544.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		13,906.5	21,481.2
1181	Газрын төлбөр		19,408.4	22,536.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		32,001.4	40,527.0
1183	Бусад татвар		0.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		97,757.9	142,977.5
120	Нийтлэг татварын бус орлого		95,557.9	142,977.5
121	Хөрөнгийн орлого		2,200.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,794,306.3	2,154,525.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,725,426.2	2,070,190.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,725,426.2	2,070,190.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,865,879.8	1,987,318.6

Дундговь аймгийн Гурвансайхан сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,246,152.9	1,272,226.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		154,148.1	161,797.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		199,028.7	215,706.8
2104	Хангамж, бараа материалын зардал		54,226.1	62,119.4
2105	Нормативт зардал		47,295.8	101,555.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		16,594.8	49,205.6
2107	Томилолт, зочны зардал		9,132.4	7,129.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		40,263.8	23,802.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		99,037.2	93,775.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		859,546.4	82,871.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		292,286.5	419,060.1
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		153,584.7	388,163.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		153,584.7	388,163.5
2200	Дотоод эх үүсвэрээр		153,584.7	388,163.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-153,584.7	-388,163.5
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		0.0	-45,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		0.0	45,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		138,701.8	-14,103.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		297,231.5	435,933.3
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		435,933.3	421,829.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,651,707.8	2,321,081.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,107,109.6	1,977,999.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,072,255.9	1,943,175.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,253,714.1	1,240,708.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	158,928.1	157,829.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	213,411.4	213,213.2
2104	Хангамж, бараа материалын зардал	54,153.9	53,946.4
2105	Нормативт зардал	60,038.4	60,036.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	118,088.3	117,913.0
2107	Томилолт, зочны зардал	8,391.0	7,029.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,433.9	7,957.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	197,096.8	84,541.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,853.7	34,824.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,853.7	34,824.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	438,547.8	298,081.7
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	106,050.4	45,000.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,651,707.8	2,332,114.1

**Дундговь аймгийн Гурвансайхан сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,427,620.0	1,427,442.1
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	795,654.3	791,087.7
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	21,621.2	9,446.9
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	406,812.3	104,137.3
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	334,583.4
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	345,616.1
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6	6
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	112	112
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	494	320
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	394	320
630001	Төрийн өмчит ЕБС	394	320
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	112	112
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8	5
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	37	36
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	5	5
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	20	19
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	32	32
650010	Гэрээт ажилтан	2	6
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8	9

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	199,865.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	199,865.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	151,996.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	31,517.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,967.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,493.5
2104	Хангамж, бараа материалын зардал	8,745.7
2105	Нормативт зардал	41,519.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,763.7
2107	Томилолт, зочны зардал	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,845.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,043.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,869.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,714.1
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	23,155.2
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	202,017.2
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	202,017.2
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	2,151.5
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,151.5

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны

дагуу Дундговь аймгийн Гурвансайхан сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Т.Оюун-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг дарга 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 1/34 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ОРЧИН БА ДОТООД ХЯНАЛТ**

Дундговь аймгийн Гурвансайхан сум нь эрхэм зорилгоо “Төрийн бодлого, шийдвэр, үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх, сумын тогтвортой хөгжлийг хангахад Засаг даргад бүх талын дэмжлэг үзүүлэх, нутгийн захиргааны манлайллыг дээшлүүлэх замаар иргэдэд төрийн чанартай үйлчилгээг үзүүлэх талаар үр нөлөөтэй үйл ажиллагаа явуулдаг эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн, байнга суралцагч мэргэшсэн тогтвортой, санаачилгатай цомхон чадварлаг алба байхад оршино” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Санхүү, төрийн сангийн хэлтсийн дотоод хяналтаас төсөвт байгууллагуудын 5 дугаар сарын санхүүгийн үйл ажиллагаанд хяналтыг хийж, тайланг Засаг даргад хүргүүлсэн байна. Мөн аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ээс төсөвт байгууллагууд болон сумын үйл ажиллагаанд жил бүр хяналт, шалгалт, үнэлгээг хийж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Гурвансайхан сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,124,927.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 31,249.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 21,874.5 мянган төгрөгөөр тогтоосон.

### 3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.5.1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дундговь аймгийн Гурвансайхан сумын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,224,606.3 мянган төгрөгөөр буюу 25.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцооны данс байна.

#### Хүснэгт 1

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	435,933.3	421,829.9	(14,103.4)
Авлага	197,217.8	247,583.8	50,366.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	309,931.1	274,316.3	(35,614.9)
Үндсэн хөрөнгө	7,671,305.7	9,895,264.2	2,223,958.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>8,614,387.9</b>	<b>10,838,994.1</b>	<b>2,224,606.3</b>
Өр төлбөр	1,910,247.6	1,910,426.7	179.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,704,140.2	8,928,567.4	2,224,427.2
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>8,614,387.9</b>	<b>10,838,994.1</b>	<b>2,224,606.3</b>

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 9,895,264.2 мянган төгрөг болж өмнөх оноос 2,223,958.6 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан ЗДТГ-ын барилгыг орлого авч тайлагнасангай холбоотой байна.

Үйл ажиллагааны орлого 5,363,341.7 мянган төгрөг буюу өмнөх оноос 1,853,465.7 мянган төгрөгөөр өссөн, үйл ажиллагааны зардал 3,124,927.7 мянган төгрөг буюу өмнөх оноос 69,572.0 мянган төгрөгөөр буурсан байна. Үйл ажиллагааны орлогын өсөлт нь ЗДТГ-ын барилгыг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор тайлагнасангай, үйл ажиллагааны зардлын бууралт нь орон нутгийн төсвийг бууруулан баталсангай тус тус холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 8,928,567.4 мянган төгрөг болж өмнөх оноос 2,224,427.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн өссөнөөс тус тус шалтгаалжээ.

### 3.5.2 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Гурвансайхан сумын төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 162,300.0 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлөвлөгөөтэй, гүйцэтгэлээр 230,588.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 142.1 хувиар биелүүлсэн байна.

#### Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
<b>Татварын орлого</b>				
Үйл ажиллагааны орлого	47,000.0	28,450.9	(18,549.1)	60.5
Хадгаламжийн хийгийн орлого	23,400.0	34,397.7	10,997.7	147.0
Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	-	4,440.0	4,440.0	
Бууны албан татвар	1,200.0	1,046.0	(154.0)	87.2
Улсын тэмдэгтийн хураамж	3,200.0	1,441.7	(1,758.3)	45.1
Хог хаягдлын үйлчилгээ	7,000.0	19,242.8	12,242.8	274.9
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	600.0	796.8	196.8	132.8
Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж	20,000.0	40,527.0	20,527.0	202.6
Газрын төлбөр	14,400.0	22,536.4	8,136.4	156.5
Малын тоо толгойн албан татвар	40,000.0	73,266.4	33,266.4	183.2
Дүн	156,800.0	226,145.6	69,345.6	144.2
<b>Татварын бус</b>				
Хүү торгууль	4,300.0	2,882.5	(1,417.5)	67.0
Бусад орлого	1,200.0	1,560.0	360.0	130.0
Дүн	5,500.0	4,442.5	(1,057.5)	80.8
Нийт дүн	162,300.0	230,588.1	68,288.1	142.1

Эх сурвалж: Гурвансайхан сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үйл ажиллагааны орлого 18,549.1 мянган төгрөгөөр тасарсан, хадгаламжийн хүүгийн орлого 10,997.7 мянган төгрөг, хог хаягдлын үйлчилгээний хураамж 12,242.8 мянган төгрөг, агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж 20,527.0 мянган төгрөгөөр тус тус давсан нь материаллаг дүнтэй байна.

Үйл ажиллагааны орлого 18,549.1 мянган төгрөгөөр тасарсан нь арьс шир ноосны урамшуулал олгогдоогүй, агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж 2 дахин давж биелсэн нь жилийн эцэст Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас нэмж 1 аргаль агнах зөвшөөрөл олгосонтой холбоотой байна.

### 3.6 ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ ТӨСӨВ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Гурвансайхан сумын ИТХ-ын 2020 оны 10 дугаар тогтоолоор сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,632,209.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,632,209.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, баталсан байна.

Гурвансайхан сумын ИТХ-ын 2021 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан төсөвт тодотгол хийж, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг тус бүр 29,642.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 2,661,851.6 мянган төгрөгөөр баталсан байна. Тусгай зориулалтын шилжүүлэг болон орон нутгийн төсвийг нэмэгдүүлэн, урсгал зардлыг нэмэгдүүлэн хөрөнгийн зардлыг хасаж баталсан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар төсвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2,651,707.8 мянган төгрөгөөр тайлагнасан нь батлагдсан төсвийг сумын ИТХ-ийн шийдвэргүйгээр 10,143.8 мянган төгрөгөөр бууруулан тайлагнасанатай холбоотой байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн гүйцэтгэлийн тайлангаар сумын Засаг даргын хэрэгжүүлэх 12 хөтөлбөрт зориулан 2,651,707.8 мянган төгрөгийн төлөвлөгөөг тайлагнаснаас 2,107,109.6 мянган төгрөгийг урсгал зардалд, 438,547.8 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 106,050.4 мянган төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар төлөвлөжээ.

Нийт зардлын 1,427,620.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 795,654.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 21,621.2 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 406,812.3 мянган төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,427,442.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 791,087.7 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 9,446.9 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 104,137.3 мянган төгрөг, нийт 2,332,114.1 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,321,081.4 мянган төгрөг буюу 87.5 хувьтай байгаа нь урсгал зардал 129,110.8 мянган төгрөг, хөрөнгийн зардал 140,466.1 мянган төгрөг, эргэж төлөгдөх зээлийн гүйлгээ хийгдээгүйгээс 61,050.4 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 177.9 мянган төгрөгийг улсын төсөвт, 4,566.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 23,159.2 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 140,452.5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 38,405.5 мянган төгрөг, нийт 202,017.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлстэй холбоотой зардалд 35,485.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 2,493.5 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 8,745.7 мянган төгрөг, нормативт зардал 41,159.8 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 20,763.7 мянган төгрөг, томилолт зочны зардалд 100.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 15,845.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 27,043.1 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 24,714.1 мянган төгрөг, нийт 176,710.5 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 23,155.1 мянган төгрөгийг төвлөрүүлж, үлдэгдэл 2,151.5 мянган төгрөгийг харилцахын үлдэгдлээр тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 АСУУДЛЫГ ОНЦОЛСОН ХЭСЭГ БА БУСАД АСУУДЛЫН ХЭСЭГ**

Тайлант онд санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын үйл ажиллагаанд дараах онцлох асуудлууд байна. Үүнд:

Засаг даргын Тамгын газар:

1. Дулааны эрчим хүчний үйлчилгээг Ган-Илч ХХК-тай гэрээ байгуулан авдаг байна. Тайлант онд Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар 14-ний өдрийн 468 тогтоолоор халаалтын үнийг м<sup>3</sup> тутамд 1500 төгрөг болгон өсгөснөөс Ган-Илч ХХК нь 34,390.0 мянган төгрөгийн нэхэмжлэхийг ирүүлсэн боловч гэрээнд өөрчлөлт оруулаагүй тул гэрээний үнэ 32,720.6 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,139,470.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй оффисын барилгыг 2020 оны 10 дугаар сард ашиглалтад оруулж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 86 дугаар тогтоолоор үндсэн хөрөнгийн дансанд орлого авч, бүртгэл тайланд тусгасан байна.

3. Нийгмийн хариуцлагын хүрээнд “Эко глобал ложистикс” ХХК-аас сум, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор 10,000.0 мянган төгрөгийг хандивласан байна. Тус хандивыг Төсвийн тухай хуулийн дагуу ОНХС-гийн дансанд төвлөрүүлэн сумын хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтад зарцуулах байсан боловч нэмэлт санхүүжилтийн дансанд хүлээн авч урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

4. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас байгалийн гамшигт үзэгдэл болон ковид цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан 15,659.2 мянган төгрөгийн хандивыг өгсөн

Эрүүл мэндийн төв:

1. Ковид-19 цар тахал тархсантай холбоотой тайлант онд тусламж хандив, төсвийн өөрийн хөрөнгөөр нийт 214,962.7 мянган төгрөгөөр эм боох материал, хамгаалах хувцас, хэрэгсэл, эмийн багц, ковидын тест, дархлаажуулалтын вакцин орлого авч, 214,444.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2. Ковид-19 халдварын цар тахалтай тэмцэх арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн яамнаас эм, эмийн хэрэгслүүдийг аймгийн Эрүүл мэндийн газраар дамжуулан хуваарилсан байна. Хуваарилсан эмийн нэг бүрийн үнийг оронгийн цэг, таслалын алдаанаас 10 дахин өсгөж илүү нэхэмжилсэн 90 ширхэг эмийн үнийн зөрүү 1,156.6 мянган төгрөгийн зөрүү, анхан шатны баримтыг ирүүлээгүй тул орлого аваагүй байсан 2,328.4 мянган төгрөгийн эмийг Эрүүл мэндийн газартай тооцоо нийлж, санхүүгийн тайланд тусган залруулга хийсэн байна.

### **3.8 АУДИТЫН ГОЛ АСУУДАЛ**

Санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудаас Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй буюу хандив, тусламжийн орлогыг ОНХС-гийн дансанд төвлөрүүлээгүй зарцуулсан, төсвийг анхан шатны баримтын бүрдэл дутуу, орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй зардалд зарцуулсан, нэмэгдлийг заасан хувь хэмжээнээс хэтрүүлэн олгосон зэрэг зөрчил илэрсэн нь аудитын гол асуудал байна гэж үзлээ.

### **3.9 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Гурвансайхан сум нь 2021 онд нийт 250,784.0 мянган төгрөгийн 165 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн, хугацаанд нь байршуулахаас 4 мэдээллийг байршуулаагүй, 16,679.9 мянган төгрөгийн 5 мэдээллийг дутуу мэдээлсэн байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол, Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 292 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Аж ахуйн харилцааны дүрэм” зөрчсөн зөрчлүүдийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт, албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газар, Тусгай зориулалтын сангууд, Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэгийн 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийсэн. Завсрын аудитаар нийт 87,730.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 81,685.4 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 237.8 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 6,045.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлжээ.

Завсрын аудитаар тогтоосон 237.8 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, 508.4 мянган төгрөгийн зөрчил арилгах албан шаардлагыг хэрэгжүүлэн, хэрэгжилтийг холбогдох байгууллагууд албан бичгээр ирүүлсэн байна.

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын төсвийн шууд захирагч нарт 4,922.9 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт, 40,149.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 5 албан шаардлага, 2 заалт зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт 48 хувьтай байна.

Хэрэгжилт дутуу төлбөрийн акт нь Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн төлбөр бөгөөд өмнөх онд ковид цар тахлын ...

*Хүснэгт 8 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт	Биелэлт	Биелэгдээгүй	Хэрэгжилтийн хувь
----------	---------------------	---------	--------------	-------------------

Дундговь аймгийн Гурвансайхан сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	3	35,549.2	2	7,808.0	1	27,741.2	22.0
Албан шаардлага	9	17,840.1	9	17,840.1			100.0
Зөвлөмж							
<b>Нийт</b>	<b>12</b>	<b>53,389.3</b>	<b>11</b>	<b>25,648.1</b>	<b>1</b>	<b>27,741.2</b>	<b>48.0</b>

### 3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн байгууллагуудын шатахуун, хүнсний материал, Эрүүл мэндийн төвийн эмийн зарцуулалтад дараагийн завсрын аудитаар горим, сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

#### 4. Аудитын илрүүлэлт

Сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагад дүгнэлт гаргаж, 7 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

#### Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 312,467.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 181,257.8 мянган төгрөгийн 12 алдааг аудитын явцад залруулж, 26,498.9 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 101,736.2 мянган төгрөгийн 17 зөрчлийг арилгах албан шаардлага, 2,974.6 мянган төгрөгийн зөрчлийг арилга зөвлөмжийг хүргүүлээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 42.0 хувийг залруулагдаагүй, 58.0 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

#### Сумын нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Орон нутгийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тусгай зориулалтын сангуудын тайланд хийсэн аудитаар нийт 121,814.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 4,570.5 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 117,244.0 мянган төгрөгийн 3 зөрчлийг арилгах зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 96.2 хувийг залруулагдаагүй, 3.8 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Нийт алдаа зөрчлийг ангиллаар нь харуулбал нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой 181,441.4 мянга, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 69,604.5 мянга, арвилан хэмнэлттэй холбоотой 237.8 мянга, дотоод хяналт, хариуцлагатай холбоотой 6,554.4 мянга, худалдан авалттай холбоотой 59,200.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил тус тус илэрсэн байгаа нь дотоод хяналтыг сайжруулан нягтлан бодогч нарын ур чадвар, хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

#### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Мал хамгаалах сангийн бараа материалын 4,570.5 дутагдлыг үр дүнгийн тайланд зардлаар тайлагнасан;

#### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Сумын ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 23 дугаар тогтоолоор 2021 оны төсөвт тодотгол хийхдээ эд хогшил, урсгал засварын зардлыг 10,988.1 мянган төгрөг байсныг тодотголоор 118,088.3 мянган төгрөг болгож 107,100.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталж Засгийн газрын 2021 оны 2-р сарын 17-ны өдрийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43-р тогтоолын 1.1-т /*үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*/, 1.4 /*энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх*/ заасныг тус тус зөрчсөн байна.

##### Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсөвт тодотгол хийхдээ холбогдох хууль, тогтоомжийг баримтлан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулж байх.

2. Орон нутгийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Батлагдсан төсвийг сумын ИТХ-ийн шийдвэргүйгээр 10,143.8 мянган төгрөгөөр бууруулан тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2-т /*тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх*/; 65 дугаар зүйлийн 65.1.1-т /*тухайн шатны төсвийн төсөл, тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах*/ заасныг тус тус зөрчсөн байна.

##### Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсөвт тодотгол хийх, өөрчлөлт оруулахдаа холбогдох хууль, тогтоомжийг баримтлан сумын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж байх.

3. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой:

##### Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд 4 мэдээллийг мэдээлээгүй, 26.0 сая төгрөгийн 5 мэдээллийг дутуу мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн /*Шилэн дансны зарчим*/ 4.1.3-т /*тогтоосон хугацаанд, тогтмол, иуурхай мэдээлдэг байх*/ заасныг тус тус зөрчсөн байна.

##### Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандарт тогтоосон журмыг уншиж судлан хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэл байршуулах ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулах;

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 7 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:</b>											
1	ЕБС	2	-					2	-		
	Цэцэрлэг	1	-							1	0
2	Соёлын төв	1	2,484.3					1	2,484.3		
	ОНХС	2	59,200.0					2	59,200.0		
3	ЗДТГ	3	20,023.6					2	17,049.0	1	2,974.6
4	ИТХ	1	430.0					1	430.0		
5	ТТЗ	2	107,100.2							2	107,100.2
	Дүн	12	189,238.1	0	-	0	-	8	79,163.3	4	110,074.8
<b>2. Бусад батламж мэдэгдлийн хүрээнд:</b>											
<b>1</b>	<b>ЕБС</b>	9	32,359.8	5	31,238.4			4	1121.4		
1	Цэцэрлэг	4	4,786.3	2	2,255.3	1	237.8	1	2,293.2		
2	ЭМТ	4	75,458.3	3	74,543.2			1	915.1		
3	ЗДТГ	7	92,964.3	2	73,221.0	1	1,500.0	4	18,243.3		
4	ИТХ	0	-								
5	ОНХС	0	-								
6	СХС	1	24,761.1			1	24,761.1				
7	ТЗС	1	4,570.5	1	4,570.5						
8	ТТЗ	1	10,143.8							1	10,143.8
	Дүн	27	245,044.0	13	185,828.3 1	3	26,498.9 3	10	22,572.96	1	10143.8
	<b>Нийт зөрчлийн дүн</b>	39	434,282.1	13	185,828.3	3	26,498.9	18	101,736.2	5	120,218.6